

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-16</i>

1.Инфляцын нөхцөл байдалтай холбогдуулан Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах хуулийн хэрэгжилтийн талаарх Монголбанкны мэдээлэл сонсох	3-16
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 12 дугаар сарын 13-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 12 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Ц.Даваасүрэн, О.Цогтгэрэл;
Чөлөөтэй: Н.Ганибал, Ч.Хүрэлбаатар, Б.Энхбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг.

Нэг.Инфляцын нөхцөл байдалтай холбогдуулан Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах хуулийн хэрэгжилтийн талаарх Монголбанкны мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны зөвлөх Б.Нандингэрэл нар байлцав.

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Инфляцын нөхцөл байдалтай холбогдуулан Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Т.Энхтүвшин, Ц.Цэрэнпунцаг нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг Инфляцын нөхцөл байдалтай холбогдуулан Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах хуулийн хэрэгжилттэй холбогдуулан боловсруулсан Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Банкны хувьцаа эзэмшлийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон инфляцын өсөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 48 минут үргэлжилж, 18 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
15 цаг 12 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Дамбын Батлут гишүүн орон нутагт ажиллаж байна. Хассуурийн Ганхуяг гишүүн өвчтэй. Одонгийн Цогтгэрэл гишүүн орон нутагт ажиллаж байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн мөн орон нутагт ажиллаж байна. Ингээд бусад гишүүд Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 55,6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Банкны хувьцаа эзэмшлийн талаар хууль тогтоомжийн хэрэгжилт болон инфляцын өсөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл сонсох гэсэн нэг асуудал хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол банкныхныг оруулаарай. Монгол банкныхныг оруулаарай. Хэлэлцэх асуудал 1.

Банкны хувьцаа эзэмшлийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт болон инфляцын өсөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл сонсож эхэлье.

Мэдээллийг Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн танилцуулна.

Мөн Монголбанкныхнаас энд ирсэн хүмүүсийг танилцуулъя. Бядрангийн Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Дунхүүгийн Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Атарбаатарын Энхжин Монголбанкны Нөөцийн удирдлага Санхүүгийн зах зээлийн газрын захирал.

Ингээд Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээнэ үү? Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн микрофоныг нээе.

Б.Лхагвасүрэн: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

Тэгээд Улсын Их Хурал 2021 онд Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 2 үндсэн ийм зарчмын томоохон өөрчлөлтийг хийсэн байгаа.

Нэг нь нийт банкны системийн банкнуудыг хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болгох. Ялангуяа түүн дотроо системийн нөлөө бүхий банкууд нь олон нийтэд хувьцаагаа IPO-оо хийж арилжаалах нэг ийм томоохон өөрчлөлт.

Нөгөөдөх нь нэг хувьцаа эзэмшигчийн төвлөрлийн дээд хязгаар буюу 20 хувийг тогтоож тодорхой хугацааны хүрээнд энэ 20 хувь руугаа оруулахаар ийм хуулийн өөрчлөлтийг 2 томоохон өөрчлөлттэй ийм хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон байгаа.

Хуулийг дагаад хуулийг дагаж мөрдөх тухай ийм журмын тухай хууль бас орсон. Үүгээр ялангуяа тэр ХК-ийн хэлбэрт шилжиж байгаа системийн нөлөө бүхий 5 том банкиг 2022 оны 06 сарын 30-ны дотор олон нийтэд хувьцаагаа арилжаалах, хувьцааны төвлөрлийн 20 хувийг 2023 оны 12 сарын 31-ний дотор энэ хэмжээнд хүргэж бууруулахаар ингээд хуульд ийм хугацааны 2 заалт орсон байгаа. Тэгээд системийн нөлөө бүхий 5 банк IPO хийж хувьцаагаа нийтэд арилжаалсан. 5 хувиас 11,6 хувь хүртэл ийм хувьцааг арилжаалсан. Одоо ингээд хувьцааны арилжаалсан нийт дүнгээрээ 473 тэрбум төгрөг боссон байгаа, 73 тэрбум төгрөг. Тэгээд хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийн хэмжээ ингээд тодорхой хэмжээгээр буурсан. Санхүүгийн салбарт ингээд 70 мянган хувьцаа эзэмшигчтэй болсон байгаа, энэ IPO хийсний дараа.

Тэгээд өнөөдөр ингээд 12 сарын 31 буюу 2 дахь заалтынх нь хувьцааны төвлөрлийг 20 хувьд оруулахаар ингээд хууль үйлчлээд явж байгаа. Гэхдээ асуудал нь яг хувьцаа хийж байхад хувьцааны IPO хийж байхад яг ковидын үе таарсан. Дараа нь энэ олон улсын геополитикийн хурцалмал нөхцөл байдалтай холбогдуулаад дэлхийн нийтээрээ инфляц өндөр, Төв банкнуудын бодлогын хүү бас маш өндөр байгаа. Үүнтэй нь холбогдуулаад хөрөнгө оруулах энэ зардал нэмэгдсэн, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхол бас яг энэ цаг үеийнхээ нөхцөл байдалтай холбогдуулаад бас тодорхой хэмжээнд сайжрахгүй байгаа. Яагаад гэвэл бодлогын хүү өндөр учраас. АНУ-ын бодлогын хүү өнөөдөр 5,75. Тэгэхээр 5,75 хувийн хүүтэй эх үүсвэрийн зардалтай

мөнгийг авчраад Монголын Хөрөнгийн биржид оруулаад Монголын хувьцаа эзэмшигчдийн хувьцааг авна гэдэг нь маш их зардалтай хөрөнгө оруулалт болох учраас энэ үүднээсээ бас энэ хувьцааны төвлөрлийг бууруулах, ялангуяа тэр 20 хувийг доош нь оруулахад ийм төвөгтэй зүйлүүд байна гэж харж байгаа юм.

Монголбанк өөрөө анх энэ 21 оны хуулийн өөрчлөлтөд оруулах өгсөн төслийн санал дээр дэлхийн бусад улсуудын жишгийг харахад нэг дунджаар нэг 5 жил, тэгээд цаашилбал бүр 7, 8 жилдээ ингээд энэ өөрчлөлтийг хийж явсан туршлага байдаг юм байна лээ. Энэ туршлагынх нь дагуу бидний санал 21 онд орсон өөрчлөлтийг 5 жилийн хугацаанд хийе. 26 он гэхэд энэ 20 хувийн төвлөрлийг бууруулах энэ боломжтой болов уу. Бусад улсын жишгээр гэдгээрээ оруулсан боловч яг хууль батлагдахдаа 23 оны 12 сарын 30 нэгэндээ дуусга гэдгээр ингээд хууль харагдаад ингээд нэлээн шахагдаад явж байгаа. Тэгээд энэ 23 оны 12 сарын 31-нд энэ заалтад оруулах боломж нь 1 дүгээрт, маш хомс байгаа. Тэр утгаараа үүнийг хугацааг нь жоохон сунгаж өгч болох болов уу гэсэн ийм бас саналтай байгаа.

Өөр нэг зүйл нь гэвэл өнгөрсөн оны, энэ оны 6 сард ОУВС-ийн бас баг ирж ажилласан. Тэгээд жил болгон ирж ажиллаад, дүрмийн 4 дүгээр заалтаараа ингээд бас зөвлөмж маягийн юмыг Монгол Улсад үлдээгээд явдаг. Зөвлөмж дээрээ бас энэ өөрөө хэт шахуу байна. Энэ шахуу байгаа нь өөрөө бас тодорхой хэмжээний эрсдэлүүдийг авчрах магадлалтай байна. Учир нь 1 дүгээрт, Монголын Хөрөнгийн бирж дээр зөвхөн таваасаа арван нэгхэн хувийг ингэж худалдан борлуулахад 470 тэрбум төгрөг ингэж шаардагдсан юм чинь, 60 хувьтай, 70 хувьтай хувьцаа эзэмшлийг доош нь буулгахад тэр 50 хувь, 30 хувь, 40 хувийг нь борлуулахад Хөрөнгийн бирж дээр ийм хэмжээний эх үүсвэр олдохгүй байх магадлалтай байна. Тэр утгаараа нэг ийм асуудал үүсэх нь.

2 дугаарт гэвэл, яах вэ, Банкны тухай хуулиар зөвшөөрөгдсөн 20 хувиас дээш хэсгийнх нь саналын эрхийг түдгэлзүүлэх маягаар ингээд явах хуулийн гаргалгаа байгаа ч гэсэн энэ нь өөрөө хувь нийлүүлэгчдийн хурал дээрээ тодорхой хэмжээний маргаан үүсгэх, засаглалын хямралд оруулах бас ийм эрсдэл байна шүү. Тэр утгаараа хугацаагаа сунгаад явсан нь зөв байна гэдгээрээ бас зөвлөмж үлдээсэн байгаа юм. Тэгээд үүнийх нь дагуу ер нь Монголбанкнаас ерөнхийдөө хугацааг нь сунгавал яасан юм бэ гэдэг бас ийм саналтай байгаа.

Өөр нэг зүйл нь гэвэл манай Банкны хуулийн 2010 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр нэг банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нөгөө банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглосон ийм заалт байдаг. Энэ нь өөрөө гаднын ялангуяа олон улсын санхүүгийн байгууллагууд ЕСБХБ, ОУСК эс үгүй бол АХБ гээд нэг банк дээр хувь эзэмшээд байж байгаа ялангуяа 10-аас дээш хувь буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болчихсон эдгээр байгууллагууд өөр банк дээр орох болохоор ийм хязгаар тавиад байна. Тэгэхээр бидэнд энэ хуулийн гарц гаргалгааг бас гаргаж өгөөч ээ гэдэг хүсэлтээ тавиад явж байгаа. Тэгээд энэ утгаараа бас өнөөдөр энэ Банкны тухай хуульд ерөнхийдөө бас энэ чиглэлийн дагуу өөрчлөлт орвол бас банкны төвлөрлийг бууруулахад нэмэртэй. Дээр нь гаднын ялангуяа ийм нэлээн сайн туршилага бүхий олон улсын сайн туршилагыг Монголын банкны салбарт нэвтрүүлэхээр ийм хөрөнгө оруулагчдад бас боломжийг нь гаргах нь зүйтэй юм байна гэдгээрээ бас энэ нэг саналыг дэвшүүлээд явж байгаа.

Товч танилцуулга юм байна. Би гишүүдэд нарийн асуулт байвал дэлгэрэнгүй хариулж өгье.

Ц.Цэрэнпунцаг: Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү, дараарай. Баттөмөр гишүүнээр

тасаллаа. Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Цаг үеийн нөхцөл байдлаас үүдээд бас шуурхай арга хэмжээ авах чиглэлээр ийм тогтоол, Байнгын хорооны тогтоол гаргахаар оруулж ирж байна гэж харж байна. Энэ дээр бас хэд хэдэн цаг үеийн зүйлүүд байх шиг байна л даа.

Лхагвасүрэн захирлаас нэг юм асуухад сая та бүхэн маань хэллээ. Өнөөдөр мөнгөний нийлүүлэлт чинь бараг 23,6 хувиар өсчхөөд байхад инфляц өнөөдөр 8,6 хувиар гарсан гэж хэлж байна. Өөрөөр хэлбэл 2022 оны 11 сард 14,6 хувьтай байсан инфляц өнөөдөр 2023 оны 11 сард жишээ нь 8,6 болж бараг 5,3 нэгж хувиар буурсан гэж үзэж байна л даа. Тэгэхээр инфляц буурах нь өнөөдөр би хэлж байна. Мөнгөний нийлүүлэлт ийм өндөр 23,6 хувиар өсчихсөн байхад яаж инфляц ингээж гараад байна. Энэ юутай холбоотой байна вэ. Яаж ч гэсэн ингээж гарах л магадлал тун бага харагдаад байгаа байхгүй юу. Зүгээр эдийн засгийн талаасаа аваад үзэхэд. Тэгээд инфляцаар, бас харахад нийлүүлэлтийн инфляц өнөөдөр би энэ биш. Гол нь эрэлтийн инфляц байгаад байгаа шүү дээ тийм ээ, энэ импортын инфляц тэгээд л ингээд хараад байхад. Тэгэхээр энэ дээр чинь сая сүүлийн нөгөө статистикийг ингээд л харахад 3 аравны нэгж хувь нь инфляц импортын барааных буюу 36 хувь нь энэ өөрөө, 5,5 нэгж хувь нь буюу 64 хувь нь дотоодын бараа үйлчилгээнээс үүдэлтэй инфляц ингээж буурсан гэж байгаа. Гэтэл Үндэсний статистикийн газрын яг энэ 2012 оны 12 сарын 01-ний байдлаар, 2023 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар ихэнх бараа бүтээгдэхүүний үнэ ханиш өссөн гэсэн статистик дүн гаргасан байна л даа. Ялангуяа хөдөө орон нутагт гээд хэлсэн байна. Тэгэхээр ингээд статистикуудын уялдаа холбоо, авцалдаа жоохон өөр өөр байгаад байгаа юм. Энд яг статистикийн сүүлийн мэдээллийг би

харж байна л даа. 2012 оны 11 дүгээр сарын байдлаар хүнсний гол нэрийн зарим барааны үнэ хани өссөн үзүүлэлттэй гарсан байна гээд тэгж байгаа. Түүн дээр мэдээж тэр хонь, ямаа, гурил гээд л нэрлэсэн байна лээ л дээ. Тэгэхээр энэ инфляцыг тайлбарлаач. Мөнгөний нийлүүлэлттэй уялдаад инфляцын энэ буурсан шалтгаан нь яг юу вэ гээд 1 дүгээрт асууя. Яагаад гэвэл энэ тогтоолын нэг гол нь инфляцыг тогтворжуулах хүрээнд гэж байна шүү дээ. Тэгэхээр энд нэг хариулт авъя.

2 дахь нь хамгийн сүүлийн заалт дээр эдийн засагт үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, инфляцыг тогтворжуулах хороонд жишээ нь нөгөө газрын тосны бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжихэд шаардлагатай санхүүжилтийн хугацааг сунгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах гэсэн байна. Тэгэхээр энэ хугацаа гэдгийг хэдий хүртэл сунгах гэж байгаа юм. Энэ нөгөө шаардлагатай санхүүжилт гэдэг нь нөгөө газрын тосны бүтээгдэхүүнийг дэмждэг, нефть импортлогч компаниудад хөнгөлөлт үзүүлдэг ч гэдэг юм уу нэг тийм бодлогууд явж ирсэн шүү дээ. Тэгээд энэ нь яг ямар агуулгаар ингэж орж ирж байгаа вэ гэсэн 2 асуулт байна.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 2 номер Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Лхагвасүрэн: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тийм, оны эхнээс өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 23 хувиар өсчихсөн байгаа. 23 хувиар өсөхөд ингээд мөнгөний нийлүүлэлт мөнгө эдийн засагт мөнгөний хэмжээ өсчихсөн гэдгээрээ ерөнхийдөө хүмүүс ерөнхийдөө хардаг.

Мөнгөний нийлүүлэлт эм 2 маань өөрөө 2 хэсгээс бүрдэж байгаа юм. Нэг нь дотоод актив, нөгөөдөх нь гадаад актив гээд. Тэгэхээр дотоод актив бол

өөрөө нөгөө зээл байгаа. Гадаад актив гэдэг Монгол Улсын валютын нөөц. Тэгэхээр Монгол Улсын валютын нөөц өнгөрсөн оны мөн үетэй харьцуулах юм бол 28 хувиар өссөн. Одоо ингээд өнөөдөр валютын нөөцийн хэмжээ 4,2 тэрбум долларт хүрсэн байгаа. Тэгэхээр ер нь 28 хувиар өссөн гэдэг маань мөнгөний нийлүүлэлт өөрөө нөөцийн өсөлтөөрөө өссөн л гэж тайлбарлаж байгаа юм. Тэгээд тэр утгаараа ерөнхийдөө мөнгө эдийн засаг руу тийм нийлүүлэгдээгүй, харин ч дотоод төгрөгийн нийлүүлэлт нь харин багассан юм шиг ийм дүр зураг байна.

Тэгээд инфляц өөрөө 8,6 хувь гээд 11 сарын байдлаар гарсан. Зүгээр би танд яг ҮСХ-ны гаргасан яг бүтцээр нь ингээд тайлбарлах юм бол 8,6 хувь дотор импортын бараа хүнсний бус импортын бараа нь 2,7 хувь, импортын хүнс нь 0,3 хувь, махнаас бусад дотоодын хүнс гэдэг байгаа. Нөгөө гурил, гурилан бүтээгдэхүүн жишээлбэл 2,1 хувь, үйлчилгээ 1,4 хувь, махан бүтээгдэхүүн 1,2 хувь гээд ингээд задраад явж байгаа юм. Тэгэхээр энэ дотор хамгийн том 30 хувьтай хэсэг нь тэр 2,7 хувь буюу импортын бараа, хүнсний бус бараа бүтээгдэхүүн байгаа юм. Тэгэхээр ер нь инфляц бол өөрөө нийлүүлэлтийн шинжтэй л явж байгаа. Төгрөгийн эрэлтийн талаасаа мөнгө нь өөрөө идчихээд их мөнгө байгаа учраас юм аваад байгаа биш зүгээр цаанаасаа нийлүүлэлт байгаа.

Яах вэ, цаашидаа инфляц өөрөө яах вэ гэдэг дээрээ бид хэд бас хараад байгаа. Ер нь яг ковид эхлээд ялангуяа геополитикийн энэ хурцадмал нөхцөл байдал яг нөгөө Орос, Украйны дайнтай холбогдуулаад контейнерын үнэ асар их өсөж байсан. Тухайн үед яг ковидын өмнө нэг контейнер 20 тонны контейнер нэг Эрээнээс Улаанбаатар хүртэл 2000 доллар байсан бол шууд 12000 доллар болтлоо 6 дахин өсөөд. Тийм, тээвэр. Энэ үнэ өөрөө эргээд 2000 руугаа ирээд яг хуучин ковидынхоо өмнөх нөхцөл рүү

ирсэн учраас тэвэрээрээ дамжиж инфляцад орох нөлөө бараг байхгүй болсон гэж ойлгож болно.

Өшөө энэ 8,6 хувийн инфляцын өшөө нэг бараг 40 гаруй хувь нь хүнсний дотоодын хүнсний бүтээгдэхүүн байгаа. Мах байна, гурил байна, сүү байгаа, хүнсний ногоо байгаа. Тэгэхээр эдгээр бүтээгдэхүүн дээр хэрвээ тогтвортой байдал бий болох юм бол инфляц цаашаа бас өсөхгүй байх боломжтой гэж Төв банкны зүгээс харж байгаа.

2 дахь асуудлын хувьд энэ шатахуунтай холбоотой. 2021 оны 10 сард шатахууны бас хомсдол үүсэж байсан. Тухайн үед Засгийн газраас газрын тосны бүтээгдэхүүний импортлодог компаниудыг нөөцийг тогтоох ийм 311 дүгээр ийм тогтоол батлагдаад ялангуяа шатахуун импортлогч аж ахуйн нэгжид 45 хоногийн нөөцийг бүрдүүлэх, энэ нөөц бүрдүүлэхэд нь Монгол банкнаас тодорхой хэмжээний санхүүжилт гаргая гэдгээрээ ингээд тогтоол гарч байсан. Тухайн үед бодлогын хүү 6 байсан гэдэг утгаараа репо санхүүжилтээр эдгээр импортлогч нарт 707 тэрбум төгрөгийн ийм эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг 20 аж ахуйн нэгжид олгосон байсан. Түүнээс хойш төлөгдсөөр байгаад 13 аж ахуйн нэгжийн 335 тэрбум төгрөгийн ийм зээлийн үлдэгдэл байгаа. Тэгээд энэ нь өөрөө энэ 23 оны 12 сард хугацаа нь дуусаж байгаа юм. Гэтэл одоо, өнөөдөр ингээд манай гудамжинд байж байгаа нөгөө бензиний түлшний хомсдол байна. Ялангуяа тэр нь нөгөө нийлүүлэлтийн шинжтэй буюу ОХУ-аас бас тодорхой хэмжээний яг бүрэн орж ирж чадахгүй байгаа гэдгээсээ ийм хомсдол ингээд байгаад байгаа юм. Тэгэхээр нэгэнт ийм цаг үеийн энэ нөхцөл ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Лхагвасүрэн гүйцээгээд хариулчих. 2 номерыг нээе.

Б.Лхагвасүрэн: Ингээд ийм нөхцөл байдал байгаа учраас үүнийг зээлийг нь цааш нь хугацааг нь сунгаж болох уу гэдгээрээ нефть импортлогч компани, нефтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо гээд нөгөө олон нийтийн байгууллагынхаа нөгөө баахан ийм олон саналууд, хүсэлтүүд ирсэн. Тэр утгаараа ерөнхийдөө үүнийг нь үргэлжлүүлээд явбал боломжтой юм байна гэдгээ бас Төв банкны зүгээс бас харж байгаа. Ер нь энэ репо буюу Монголбанкны өөрийн санхүүжилт дээр гарсан мөнгө учраас манайд энэ өөрөө энэ хэрэгсэл нь өөрөө байдаг. Яах вэ, бодлогын хүү нэлээн сүүлд өсөөд өсөөд өнөөдөр 13 болсон гэдгээрээ санхүүжилтийнх нь зардал нь жоохон өндөр болж байгаа. Гэхдээ хугацааг нь сунгах боломж байгаа гэж Төв банкны зүгээс бас үзэж байгаа. Тийм.

Ц.Цэрэнпунцаг: Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Лхагвасүрэн Ерөнхийлөгч сая инфляц дээр яг бодит юм ярьж байна л даа. Импортын нийлүүлэлт инфляц дээр болохоор яг буурчихсан. Яг дотоодод гол хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өсчихсөн учраас энэ инфляцдаа нөлөөлөөгүй, авцалдаагүй байгаад байна шүү дээ. Гэтэл иргэд маань хамгийн гол нь нөгөө өдөр тутмын энэ гол нэрийн бараа, хүнсний бараа бүтээгдэхүүнээ үнэ нь өндөр, авахад амаргүй байгаа учраас бараг импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүн авах нь хүртэл багасчхаж байгаа байхгүй юу. Яг бодитоор ийм байгаа. Бүх иргэд ингээд л иргэдтэй уулзаж ярьж байгаа. Тэгэхээр цаашидаа сая та хэллээ, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүн дээр үнийг нь тогтвортой байлгавал инфляц буурах юм уу, инфляц тогтвортой байх магадлалтай байгаа гэж байгаа юм. Тэгээд энэ арга замыг та юу гэж бодож байгаа юм? Өнөөдрийн бодит байдлыг харахад бас бага харагдаад байна шүү дээ. Импортоо татаж ирэх нь ч байна, бараг сүүлдээ татвар нэмэх тухай асуудал хүртэл

Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны сайт дээр хүртэл гарсан байсан. Тэгээд 24 оны төсөв хэлэлцсэний дараа ингээж болох, болохгүй асуудлын жич ярих байх л даа. Тэгээд энэ дээр нэг хариулт өгөөч.

2-т нь, ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Оюунчимэг гишүүнд нэмж 1 минут өгье.

М.Оюунчимэг: Нефть импортлогч компаниудад мэдээж бараг жил болгон л иймэрхүү асуудлууд тулгараад л ингээд л репо санхүүжилтээр өгөөд л явж ирсэн. Тэгэхдээ сая таны хэлж байгаагаар 20 аж ахуйн нэгж төлчихсөн, 13 аж ахуйн нэгжийн 3 зуугаад тэрбум төгрөг нь төлөгдөөгүй байгаа юм байна тийм ээ? Үүнийг сунгах тухай асуудал ярьж байна л даа. Тэгэхээр энэ аж ахуйн нэгжүүд маань өөрсдөө бас их хариуцлагатай байх. Энэ нийлүүлэлт талаасаа нефть импууны бүтээгдэхүүнийг энд нөөц бүрдүүлэх энэ тэр дээр яаж ажиллаж байгаа юм бол. Та нар ингээд репо санхүүжилт олон жилийн турш ингээж хийж ирлээ шүү дээ. Нөгөө л нэг хэдэн нефть импортлогч компаниудтай тийм ээ. Тэгээд мэдээж нэг талаас нийлүүлж байгаа ОХУ-аас шалтгаалж байгаа зүйлүүд байгаа байх. Яг нефть импортлогч компаниудын зүгээс энэ дээр хэр хариуцлагатай байгаа юм бол оо, Ганбаатар сайд аа. Одоо яг энэ, бид нар ингээд л төр бодлогоороо репо санхүүжилтээр ингээд л дэмжээд л байна тийм ээ. Тэгээд 20 аж ахуйн нэгжийг нь төлчихсөн байхад 13 аж ахуйн нэгж төлөөгүй өнөөдөр 3 зуугаад тэрбумын зээлийг нь сунгах тухай асуудал ярьж байна. Гадаа нөхцөл байдал бензин шатахуун дээр бас амаргүй байгаа үед энэ мэдээж дэмжигдээд явах байх.

Ц.Цэрэнпунцаг: Лхагвасүрэн Ерөнхийлөгч эхэлж хариулъя, 2 номер.

Б.Лхагвасүрэн: Оюунчимэг гишүүний асуултад тодруулаад хариулъя. Тэгээд ер нь мэдээж дотоодын хүнсний аюулгүй байдал, хангамжийн асуудал нэг номерын асуудал байгаа. Тэр утгаараа Монгол Улсын Ерөнхийлөгч нөгөө Хүнсний аюулгүй байдал Хүнсний хувьсгал гээд хөтөлбөр өрнүүлсэн. Тэр хүрээндээ Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр улсын төсөв дотор 135 тэрбум төгрөгийн хүүгийн татаасыг суулгаж өгөөд энэ онд бараг 600 гаруй тэрбум төгрөгийн ийм хүүгийн татаастай хөнгөлөлттэй зээлийг ялангуяа тэр газар тариалан, хүнсний ногоо тариалан эрхлэгчдэд олгоод ингээд явж байгаа. Тэгээд яах вэ, Хүнс, хөдөө аж ахуйн яамны гаргаж байгаа статистикаар улаан буудайн хувьд 100 хувь өөрийгөө хангахаар, төмсөөр 100 хувь хангахаар, хүнсний ногоогоороо 85 хувиар хангахаар ийм хэмжээний ургац хурааж авлаа гэж яригдаж байгаа. Гэхдээ өнөөдөр бас Засгийн газрын хурал дээр яригдаад сүүлд бас Болорчулуун сайд ярианаас юу гэж ойлгосон бэ гэхээр яах вэ, намар ургац сайн болсон байсан ч гэсэн нөгөө намар нэлээн урт дулаахан болоод тэгээд дахиад тариа өөрөө ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Дараа нь та гүйцээгээд хариулчхаарай. Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Юу, энэ ингэсэн юм байна лээ л дээ. Ер нь ингээд 2016 он, 17 оноос хойш энэ бодлогын хүү их хямд байхад нь овоо их мөнгө олгож байсан юм байна лээ, 6 хувийн хүүтэй. Тэгээд тэр мөнгөнүүд 6 дээр нэмэх нь 3, 9 шүү. Нөгөө нэг бодлогын хүү 6 гээд нөгөө бас нэг 3 хувь нэмэгдээд нэг 4 хувь ч билүү нэмэгдээд, тэгээд тэр нь аль дэвийн бүгд иргэдэд төлчихсөн байгаа байхгүй юу. 7 зуугаад тэрбум төгрөг олгоно гээд. Тэгээд бүгдийг нь ч авдаггүй юм байна лээ. Эд нар чинь бас өөрсдөө тодорхой хэмжээний эргэлттэй. Тэгээд энэ 17 хувиар авсан энэ чинь бодлогын хүү чинь нэг 13, 14 болчихсон. Тэгээд 17 хувиар, 18,

19, 20 хувиар авсан аж ахуйн нэгжүүд байгаа. Тэгээд энэ чинь ингэдэг юм байна лээ л дээ, нргэн төлөөд л байдаг, төлөөд л байна тэгээд л зарим нь нөгөө хэрэгцээтэй үедээ нөгөө 8 сард нэг удаа ашиглана тийм ээ, 9 сард нөгөө оргил үедээ авна, бага үедээ буцаагаад өгчихдөг. Түүнээс биш ийм өндөр хүүтэй мөнгө байлгаад байдаггүй юм байна лээ л дээ. Зүгээр тэгээд түүнээс биш ингээд л байнга л нөгөө нэг хүн аж ахуйн нэгжүүд чинь мөнгө аваад л ингээд байдаггүй юм байна лээ. Тэгээд зүгээр энэ асуудлыг цаашаа сунгаад өгвөл яаж байгаа вэ гэхээр Оюунчимэг гишүүн ээ, угаасаа манай хэрэглээ өөрөө 40 хувиар нэмэгдчихэж байгаа байхгүй юу. Өөрөө, та өөрөө нүүрсний 30 сая тонн нүүрс гаргаж байсан айл 70 сая тонн нүүрс гаргахаар энэ хэрэглээг нөхөх эдийн засгийн санхүүгийн эх үүсвэр зайлиггүй ирэх. Одоо тэгээд хөөрхий аж ахуйн нэгжүүдийг юу гэж хэлэх вэ? Тэгээд энэ чинь зайлиггүйгээр. Тэгээд бид нар зайлиггүй 30 хоногийн нөөц хэрэг заавал байлга. Тэгээд урьдчилгаа мөнгө хойшоогоо энэ чинь нэг зарим тохиолдолд коронагаас өмнө энэ хойд айлын энэ асуудлаас өмнө нөгөө 60 хоногийн бас нэг юу муу өгдөг байсан юм байна лээ л дээ. Нэг боломж өгдөг. Одоо бол заавал урьдчилаад мөнгөө төл, 92 дээр бүр 100 хувийн кэйш төл гээд. Ингээд асуудлууд нь их хүндрэлтэй юм байна лээ. Тэгэхээр эд нар тэгэхдээ бүр бүрэн ашигладаг ч үгүй юм байна лээ л дээ. Тэгээд л заримдаа Монголбанканд бүгдийг нь төлчихдөг, заримдаа авна. Энэ чинь нөгөө нэг шугам гэдэг утгыг нь та ойлгоорой. Түүнээс биш яг бүтэн олгодог биш шугам гэдгийг нь аваад тэнд хүртэл авна. Үгүй ээ, нефть нийлүүлэлтээр асуудал байгаа Оюунчимэг гишүүн ээ. Тэгэхдээ иргэдийн очер дараалал би хэлээд, та бүхэн хэлбэл болно. Би хэлээд одоохондоо намайг нийгэм нэг их байнга л би ярьж, та түрүүн хэлсэн л дээ. Нөгөө нэг байнга хэлж байгаа учраас миний үг бас нэг нөгөө одоохондоо байнга хүрэхгүй байна. Түүнээс биш 92 дизель орж ирэх нь

хангалттай. Хэрвээ, үнэ өсөхгүй шүү дээ. Үнэ өсөхгүй. Дээрээс нь ард иргэдийн нөгөө нэг юу гэдэг юм тийм ээ, 70 хувь нь ингээд нөгөө улаан гэрэл нь асчихсан хүмүүс очиж байна, 30 хувь нь хөөрхий нөгөө нэг жоохон сандраад нөгөө банк нь дүүрэн ч нэг жоохон зураас нь доошоо явчихсан ч гэсэн очоод бас ингээд очерлож нэмэрлээд байгаа юмнууд байна.

Хэрвээ асуудал байсан бол энэ их очер дараалал үүсэж байхад тэгээд л айл хэдийн бүх колонк байхгүй гээд дуусчихна шүү дээ. Тэгээд энэ чинь өөрөө бас би тэгээд уриалаад л байгаа юм. Та бүхэн бас нэг бид нартайгаа хамтран ажиллаач ээ, битгий очерлооч ээ, нийлүүлэлт цаашидаа. Бид би мэдээллээ байнга өгч байгаа. Тэгээд дээрээс нь үнэ нэмэгдэхгүй ээ гэдгийг байнга хэлж байгаа юм. Дэлхийн зах зээл дээр угаасаа бүтээгдэхүүний үнэ унаж байна л даа. Түүхий баррел тосны үнэ саяхан бараг 95 доллар байсан байна. Одоо бүр 70 доллароос доошоо уначихсан. Тэгээд долларын ханиш нөгөө Монголд бас жоохон тогтворжиж байгаа нь бас бид нарт бас нэг тийм ээ, нөгөө юу нөөц нэмэгдэж байна шүү дээ. Бараг 4,5 тэрбум ч байна уу, долларт хүрч байна. Валютын нөөц. Тэгээд энэ чинь өөрөө нөгөө үнэ өсөх тийм ямар ч сандрах зүйл байхгүй байгаа байхгүй юу. Тэгээд тийм учраас үнэ өсөх ямар ч шалтгаан байхгүй болчихож байгаа юм. Тэгээд энийгээ би хэлээд л байгаа юм. Тийм. Баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Банкнудыг нээлттэй ХК болгох ийм ажиллагаа явагдсан. Тэгээд сая Монголбанкны Ерөнхийлөгчийг уг нь 473 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгө нэмэгдсэн. 70 орчим мянган хувьцаа эзэмшигчтэй болсон гээд энэ их сайн тоо л доо. Манай Монголбанк чинь банкны зөвшөөрөл олгохдоо 100 тэрбум билүү? Тийм ээ, доод хязгаар нь тийм ээ. Тэгээд 473 гэдэг

чинь 4,7 банкны хэмжээний тийм эх үүсвэр, 5-10 хувийг худалдахад л тийм байгаа шүү дээ. Тэгэхээр энд нэг асуулт байна л даа. Энэ нэг банканд хөрөнгө оруулалт хийхэд нөгөө банкны өөрийнх нь үнэлгээ, бас нөгөө нэг Пи Эй гэж хэлдэг, тийм ээ, нөгөө үнэ ханшийн нөгөө харьцаа, үйл ажиллагааны өгөөж, нөгөө пенстик үйлчилгээ гээд байдаг тийм ээ. Энэ болгон гол үзүүлэлт болдог гэж ингэж үздэг тийм ээ. Тэгэхээр банкнуудаа ер нь та нар яаж үнэлдэг юм бэ? Банкнуудынхаа үйл ажиллагааг 22 оны, 23 он дуусаагүй байна, 22 оны үйл ажиллагаагаар банкнуудаа ер нь яаж дүгнэдэг вэ? Ер нь зүгээр миний харж байгаагаар энэ пенстик үйлчилгээнүүд ер нь харьцангуй гайгүй яваад байх шиг байна. Бусад энэ үйл ажиллагаануудыг ер нь яаж үнэлдэг вэ гэсэн эхний асуулт байгаа.

2 дахь асуудал энэ банкнууд дээр байж байгаа эрсдэл, банкнуудын эрсдэл байна л даа. Энэ дээр гол эрсдэл яах вэ, нөгөө чанаргүй зээлийн хэмжээ. Тэгээд дээрээс нь нөгөө анхаарал хугацаа хэтэрсэн зээл, тийм ээ. Энэ 2 үзүүлэлт нийлэхээрээ банкны нийт зээл энэ 10 гаруй хувь болоод явчихдаг. Энэ хувь хэмжээ ер нь ямархуу хэмжээтэй байна. Цаашидаа хандлага ер нь ямар байна гэсэн 2 дахь асуулт байгаа.

3 дахь асуудал инфляц байгаа тийм ээ. Инфляц шууд үнийн өсөлт биш, үнийн өсөлтийн хурд шүү дээ, тийм ээ. Эдийн засгийн шинжлэх ухаанд ингэж үздэг. Үнийн өсөлтийн хурд. Тэгэхээр 8,6 хувийг нь инфляц гэдэг чинь өнгөрсөн жилийн 12, 3 хувийг инфляц дээр нэмэх нь тийм байгаа шүү дээ, тийм ээ. Тэгэхээр инфляцыг их багасгачихлаа, их сайн болчихлоо гэж бид үзээд байх үндэслэл байхгүй. Ард иргэдийнхээ орлого энэ тэртэй харьцуулах юм бол энэ их том тоо шүү дээ, 8,6 гэж. Тийм учраас энэ инфляцын 8,6 хамгийн сүүлчийнхийг, 8,6 та нар ангилж үзсэн үү? Эрэлтээр өдөөгдсөн гээд. Ханшаар өдөөгдсөн байхгүй, тийм ээ. Оны эхэнд ямар

байсныг нь сайн мэдэхгүй байна. Зүгээр нийт дүнгээрээ ямар байгаа юм бол? Эрэлтээр өдөөгдсөн 8,6-гаа та нар ангилж үзэв үү. Нийлүүлэлтээр нь хэд байна. Манай энэ инфляцын чинь дотор нь задлаад үзэхээр хүнсний бүтээгдэхүүн 13,3 хувиар өссөн байгаа юм. Тийм ээ. Нөгөө дотуур байр гээд ингээд тэр хүмүүсийн хэрэгцээний энэ юмнууд чинь бас нэг 16 хувиар өссөн. Боловсролынх нь бас 10 хэдэн хувиар өссөн ингээд л хүний яг гол хэрэгцээний зүйлүүд маань л ингэж өсөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг юу гэж харж байна? Цаашидаа ер нь оны төгсгөлд инфляц ямар байх вэ? Инфляцын хурд ямар байх вэ? Энэ дээр хийсэн судалгаанууд юу байна? Энд хариулт өгөөч?

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 2 номер. Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя.

Б.Баттөмөр: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө Төв банкны тухай хуулиар Монголбанк арилжааны банкаа хянан шалгаад ингээд явж байгаа. Манай хянан шалгалтын гол арга, яаж шалгадаг вэ гэхээр зохистой харьцааны үзүүлэлт байдаг. Тэгээд өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, таны саяын дурдсан нөгөө чанаргүй зээл ч гэдэг юм уу, ингээд бүх юм хэмжээсээр явдаг. Энэ хэсэг дээрээ л Монголбанк яг хянан шалгалт зохицуулалтаа хийхээс биш яг банкных нь дотоод юм руу бас ордоггүй. Яагаад гэвэл тэр хувьцааны үнэ ханиш тогтоох тэр хэсэг нь банкны өөрийнх нь тийм өөрөө тогтоогоод явдаг. Мэдээж хувьцааны үнэ ханшийг тогтоохдоо банкны удирдлагууд өөрөө би тэгж бодож байна гээд шууд тавих эрх байхгүй. Банк хувьцааныхаа үнэ ханиш дээр болохоор заавал бас аудитын компани оруулж ирээд санхүүгийнх нь тайланд аудит хийдэг компани энэ танай хувьцааны нэрлэсэн үнэ байна, энэ зах зээлийн үнэлгээ ийм байх юм байна гэдгээрээ ингээд тооцоог нь хийгээд

тэгээд саяын IPO хийсэн олон нийтэд хувьцаагаа гаргасан банкнуудын тэр үнэ ханиш яг тэр хөндлөнгийн үнэлгээний компаниар хийлгээд гаргасан үнэ ханиш байгаа. Яах вэ, өнөөдөр бол хөрөнгийн бирж дээр зарим банкны хувьцаа өсчихсөн байгаа. Зарим банкны хувьцаа уначихсан байгаа. Тэр нь зах зээлийнхээ л тэр хөрөнгийн бирж дээр байгаа гүйлгээний бас хэмжээнээс хамаарч байгаа юм. Түүн дээр их мөнгө байх юм бол идэвхтэй арилжаалаад явна. Бага мөнгө байх юм бол арилжаалахгүй байх юм ч юм уу, тэр утгаараа явж байгаа. Тэгээд энэ дээр шууд Монголбанк оролцоод, чи өөрийгөө хувьцаа чинь дэндүү өндөр үнэтэй байна, эс үгүй бол бага үнэтэй байна гэж оролцох эрх байхгүй. Тэрнээс зохистой харьцаагаар л явж байгаа.

Хамгийн сүүлийн яг энэ олон нийтэд хувьцаагаа арилжаалсны дараа банкны секторын өөрийн хөрөнгө бол түрүүчийн дурдаж байгаа тэр 470-аад тэрбумаар өссөн. Энэ утгаараа өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь маш өндөр байгаа. 16 хувьтай болчихсон байгаа. Ер нь олон улсын тэр базелийн хорооны тэр зохистой харьцааны үзүүлэлтээр нэг 12 хувиас доошгүй байх ёстой гэдгээрээ Монгол Улсад 4 нэгж хувиар өндөр байна гэж хэлж болохоор.

Өөр нэг зохистой харьцаа нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт. Нийт актив дотор нь хэчнээн хэмжээний бэлэн мөнгө байна? Тэр нь бараг 40 гаруй хувьтай. Олон улсын жишиг нь 25 байдаг. Тэгэхээр бас их өндөр. Тэгэхээр энэ нь өөрөө юу хэлж байна гэхээр өөрийн хөрөнгө өндөр байна гэдэг нь зээл гаргах боломжтой. Нөгөө өөрийн хөрөнгөдөө харьцуулаад явах юм бол бас төлбөр түргэн гүйцэтгэх чадвар өндөр байна гэдэг маань бас шинэ зээл гаргахад мөнгө бэлэн байна л гэж байгаатай адилхан ийм үзүүлэлт байгаа юм. Үүнийх нь хүрээнд бид хэд л шалгалтаа хийгээд л ингээд явдаг.

Таны сүүлийн асуулт дээр үнийн өсөлтийн хурд гээд тийм, үнийн өсөлтийн хурд. Хурд бол түрүүнд нь 16 хувьтай их өндөр байсан бол одоо 8 болоод ингээд буураад явж байгаа. Монголбанкны бодлогын 24 онд баримтлах үндсэн чиглэл дотор бид хэд нэг 6 нэмэх, хасах 2-ын хурдтай байхад Монголын эдийн засагт боломжийн байна гэж үздэг. Олон улсад АНУ-ын төв банк 2 хувь, Европын холбоо 2 хувь гээд л байж байна. Ер нь инфляц үнэ тодорхой хэмжээний энэ 2 хувийн өсөлттэй байхад эдийн засагт эерэг нөлөөтэй гэдгээр хардаг. Үнэ ерөөсөө өсөхгүй байвал дефляцтай улсууд байдаг. Тэдгээр улсуудад эдийн засаг цаашаа томрох боломжгүй гэдгээрээ бас ийм сөрөг талаас нь харж явдаг. Тэгэхээр мэдээж 6 хувь, 8 хувь бол гэдэг бас тийм бас өндөр хөгжилтэй улсуудтай харьцуулахад бас өндөр тоо. Яах вэ, яваандаа тийшээ оруулъя гэдгээр л чиглэлтэй байгаа.

Ер нь инфляцын өнөөдрийн энэ 8,6 хувь бол энэ дотор эрэлтийн шинж одоохондоо байхгүй байна гэж харж байгаа. Хэрвээ цаашаа өсөх юм бол эрэлтийн шинж хаанаасаа гарч ирэх вэ гэвэл саяын төсөвт тэлээд цалин, орлого нэмэгдээд явж байгаа. Энэ нь өөрөө худалдан авахыг цааш нь дэмжиж, нэлээн хөөргөнө. Тэр утгаараа үнэ өсвөл эрэлтийн шинжтэй нөлөө орж ирж байна гээд. Тэгээд бидний хувьд яг одоохондоо тэр нөлөө нь орж ирээгүй байна гэж харж байгаа. 24 оны эхний хагас руу энэ нөлөө орж ирэх болов уу гэж бас тийм төсөөлөл таамаглалаа хийгээд явж байгаа. Гэхдээ бидний хувьд 20 ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: 2 номер гүйцээгээд хариулчихъя, 1 минут.

Б.Лхагвасүрэн: Тэгээд ирэх онд 6-8 хувьдаа оруулах боломжтой гэж харж байгаа. Яагаад гэвэл угаасаа мөнгөний бодлого хатуу бодлого явж байгаа. Бодлогын хүү өндөр байгаа. Тэр

утгаараа нөгөө эдийн засагт эргэлдэх мөнгө нь өөрөө хомсдолтой. Ялангуяа аж ахуйн нэгжүүд зээл олдохгүй байна, энэ эдийн засагт мөнгө байхгүй байна гэж ярьж байгаа нь хатуу бодлогын нөлөө байна л гэж харж байгаа. Тэгэхдээ инфляцаа энэ өөрийнхөө зорилтот түвшинд оруулж байж бид нар мөнгөний бодлогынхоо төлөвийг зөөлрүүлэх үү гэдэг дээрээ дараагийн бодлогын шийдвэрийг гаргах гэж байгаа.

Түрүүчийн Оюунчимэг гишүүний асуулт нь яг сая бас Баттөмөр гишүүний асуулттай адилхан асуулт байгаа учраас яаж инфляцыг тогтворжуулах вэ, яаж үнийг тогтвортой байлгах вэ гэхээр мэдээж өрсөлдөөн чухал. Тэгэхээр нэгэнт хүнсний ногооны хангамж нь өөрөө 100 хувь биш 85 хувь байна гэдэг маань өшөө үлдсэн 15 хувь импортоос л авахаас өөр замгүй шүү дээ. Тэгж байж 100 хувь авна. Хэрвээ хомсдолтой байх юм бол үнэ цаашаа яваад л байна, өөрөө хомсдолтой байна гэдгээрээ. Тэр утгаараа би импорт дээр татвар тавих нь эргээд л үнэ ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Банкны энэ IPO дээр бас өөрчлөлтүүд гарсан. Тэгээд яах вэ, мэдээж СЗХ илүү хариулт өгөх байх. Тэгэхдээ Монголбанк бас судалгаа хийсэн байх. Нийт 70 мянган тэр хөрөнгө оруулагчийн миний тооцож байгаагаар ихэнх нь хадгаламж эзэмшигч нар байгаа. Тийм ээ, үүнийг яагаад ингэж байна гэхээр яах вэ, ашиг олох зорилгоор аваад яг стратегийн хөрөнгө оруулагч их бага байгаа юм болов уу. Яаж байна гэхээр одоо нэмэгдэхгүй байгаа. Тэр хувьцаа эзэмшигчдийн тоо хасагдчихсан байгаа юм л даа, 1 дүгээрт.

2 дугаарт, энэ хувьцааны хани уналттай болчихсон, тийм ээ. Хаан банкнаас бусад нь үндсэндээ нөгөө өрийн үнэлгээний юнаас дандаа доошоо орчихсон байж байгаа шүү дээ. Үүний

учир шалтгаануудыг та нар судалж үзэв үү, ямар учир шалтгаанууд байна? Цаашидаа үргэлжлүүлээд бид юу хийх вэ? Энэ дээр хариулт өгөөч.

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээж юу, саяын тодруулж асуусан асуултад хариулъя. Ажлын хэсгийн 2 номер. Лхагвасүрэн Ерөнхийлөгч.

Б.Лхагвасүрэн: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тийм, IPO хийснээс хойш зарим хувьцааны үнэ унаад. Тэгээд Монголбанкны зүгээс бидний үзэж байгаагаар 1 дүгээрт, хөрөнгийн бирж жоохон тэнд дахиад хувьцааг нь аваад цааш нь авахаар тийм хөрөнгө оруулагч нь гарч ирэхгүй байна. Нэг тийм 1 дүгээр шалтгаан байгаа.

2 дахь нь гэвэл IPO хийхэд 2 төрлийн хөрөнгө оруулагч орж ирж бас хувьцаа авдаг. Нэг нь нэлээн удаан хугацаанд стратегийн хөрөнгө оруулагч болоод нэлээн удаан хугацаанд банкны хувь эзэмшлээ аваад явах. Ноогдол ашигаар авах. Цааш нь үнэ өсөх юм бол тэр одоо үнэ өссөн дүнгээр өөртөө бас ашиг олох тийм хувьцаажигж байгаа. Нэг хэсэг нь зүгээр ороод л дамлах эрэлттэй буюу ороод авчхаад нэг хэсэг хугацааны дараа гараад явчихдаг гээд. Тэгэхээр яг ийм нэг хэсэг хугацааны дараа гарч явж байгаа хувьцаа эзэмшигчид үнээ яалт ч үгүй буулгаад л заръя гээд явж байгаа. Нэг ийм шалтгаан байна.

Монголбанкны бас үзэж байгаа нэлээн том нэг шалтгаан бол 5 том банкныг зэрэг явуулсан. Тэгэхээр эхний банкны хувьцааг ... /минут дуусав/

Ц.Цэрэнпунцаг: Гүйцээгээд хариулчихъя. 2 номер.

Б.Лхагвасүрэн: Эхний банкны хувьцааг авчхаад дараагийн банкны хувьцаанд оруулна гэсэн хүн бушуухан зараад авах гэж байгаа учраас ингээд ингээд хоорондоо ойртчихсон учраас бас ингээд нэлээн төвөгтэй зүйлүүд ирсэн.

Тэгээд хамгийн эхний түрүүлж гарсан банкнуудынх нь үнэ нь арай илүү түлхүү уналттай байгаад байгаа нэг тийм зүйл байгаа.

Өөр нэг зүйл нь гэвэл ер нь нэгэнт манай Монголын хөрөнгийн бирж өөрөө ингээд бага, ялангуяа саяын 470 тэрбум төгрөгөөр хувьцаагаа босгоод, дээр нь 5 банкны нийт актив хөрөнгө нийт хөрөнгийн захын нөгөө хөрөнгийн үнэлгээ болоод ороод ирнэ шүү дээ. Тэгэхээр хөрөнгийн зах өөрөө 3 дахин өссөн, энэ банкны IPO-ээс хойш. Тэгэхээр ийм том өсөлтүүд нь өөрөө тодорхой хэмжээнд ингээд бас зогсоно л доо. Энэ хурдаараа явахгүй юм чинь. Тэр утгаараа ер нь гаднын хөрөнгийн бирж шууд давхар бүртгэл маягаар дуэ листинг гэдэг. Тэгж гарах нь зөв зохистой гарц байх гэдгээрээ ингээд ярьж байгаа. Тэгээд СЗХ, Монголбанк, банкнууд бид хэд хамтраад ялангуяа ойрхон Хонконгийн хөрөнгийн бирж байдаг юм уу, Токиогийн хөрөнгийн бирж рүү гаргахаар дараагийн алхмуудаа хийхээр ингээд бас ажил зохион байгуулах гэж байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Энхтүвшин гишүүн асуултаа асууя. Асуулт, үг цуг явж байгаа шүү, гишүүд ээ, анхаараарай.

Т.Энхтүвшин: Тогтоолын төслийг дэмжиж байна. Зүгээр энэ газрын тосны бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг бас тогтвортой байлгах, шаардлагатай санхүүжилтийг нь сунгаад явах энэ арга хэмжээг дэмжиж байна. Энэ өвөл бас нэлээн хүнд болж байна. Малчид маань малаа их нядалж байна, махны үнэ хямдарчихлаа. Махны үнэ хямдрахад инфляц дагаад буудаг. Тэгээд ганц юман дээр нэг эргэлзээд байна л даа. Хавар ажилгүйдэл их болох вий, ажилгүй иргэд маш их хэмжээгээр төв суурин газар бараадаж орж ирэх вий. Инфляц энэ хэмжээгээр өснө шүү. Өнөөдөр цас зуд болж байна гээд махны үнэ уналаа. Энэ инфляцад сайнаар нөлөөлж байна гэж ингэж ярих нь

зохимжгүй байх гэж бодож байна. Миний хувьд бол.

Манай Монгол Улсын гол инфляцын хүнсний инфляцыг барьж байдаг зүйл бол ерөөсөө л мах шүү дээ. Тэгээд би юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ 3 дахь заалт дээр нь энэ Монгол Улсын хүнсний гол хэрэглээг бэлдэж байгаа малчдад энэ урт хугацаатай, тогтвортой, бага хувийн хүүтэй зээл олгох ийм бололцоо боломж байдаг юм уу? Үүнийг яагаад оруулж ирж болохгүй байгаа юм? Малчид маань өвс тэжээлээ бэлдэж чадахгүй байна, отор нүүдлээ хийж чадахгүй байна. Малаа маш их хэмжээгээр нядлаад хямд үнээр зарж байна шүү дээ. Дээр нь юу гэдэг юм малаа барьцаалаад 22, 23 хувийн хүүтэй зээл авчихсан. Маш хүнд нөхцөлд амьдарч байгаа учир энэ эдийн засгийн, эдийн засагт үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлээд энэ Монгол Улсын хүнсний бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүнийг бэлдэж байгаа малчдадаа энэ тогтвортой, бага хувийн хүүтэй зээлээ өгч яагаад болдоггүй юм бэ? Бид нар хүнсний үйлдвэрт өгөөд болж байна, та ярьж байна тэр төмс хүнсний ногоонд өгөөд болж байна гэж ярьж байна. Хөнгөн үйлдвэрлэлд өгөөд явж болж байна. Тэгээд малчдадаа энийгээ бас өгвөл яасан юм бэ? Аягүй хүнд нөхцөлд байна шүү. Үнэхээр хүнд нөхцөлд байна шүү. 2001 оны зуд байж байна. 99 онд ч билүү нийслэл Улаанбаатар хот болон хөдөө орон нутаг аймгийн төв рүү маш их хэмжээний ажилгүйдэл бий болж байсан. Энэ эрсдэлийг ер нь юу гэж харж байгаа юм бэ? Энэ хавар ер нь эдийн засаг яаж өсөх юм, уруудах юм. Энэ малчид руу тодорхой хэмжээний арга хэмжээ аваад энэ бага хүүтэй зээлийг өгөөд, өвс тэжээлээ бэлтгэх, отор нүүдлээ хийх ийм бололцоо боломжийг Монголбанк гаргаж өгөх ийм бололцоо боломж байна уу? Энэ тогтоолын төсөлд оруулчихвал ер нь болох уу, болохгүй юу гээд энэ зүйлийг асууя.

Ц.Цэрэнпунцаг: Лхагвасүрэн Ерөнхийлөгч. Энхтүвшин гишүүний асуулт асуултад хариулаарай. Ер нь энэ өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дээр бид нарын авч хэлэлцэж байгаа асуудал бол энэ банкны шинэчилсэн найруулга Банкны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор дагаж хэрэгжүүлэх журмын тухай хууль хэрэгжиж эхлэх хугацаа тулсан. Энэ дээр холбоотой асуултыг бид нар 1 дүгээрт сонсьё.

2 дугаарт, бид нар энэ ковидын үед гадаад нөхцөл байдал хүнд, дотоодод өвчинтэй. Гадаад нөхцөл байдал ингээд энэ геополитикийн нөхцөл байдал үүссэн үед бас тодорхой арга хэмжээнүүд авч явуулж, энэ эдийн засгийн эргэлт, ялангуяа энэ инфляцтай холбоотой инфляцын сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр Монголбанканд чиглэлүүд өгсөн. Ажлууд ерөнхийдөө энэ хэрэгжиж явсан. Үүний талаар ерөнхийдөө мэдээллүүд авъя гэсэн. Тэгэхээр энэ Энхтүвшин гишүүний энэ асуудлыг бид нар ойрын үед авч ярилцах ёстой зүйл. Энэ гарцаа байхгүй бид нарт холбогдож байгаа ойрын үед яригдах асуудлууд байгаа. Ийм учраас үүнийгээ бид нар БОХХААБХ-той ер нь бас хамтарч ер нь бас энэ дээр энэ асуудлыг дахиж бид нар сайн хэлэлцэнэ гэж бодож байгаа. Тийм. Тэгээд та тэр саяын холбоотой Энхтүвшин гишүүн тодорхой асуусан асуултуудыг Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулъя. 2 номер, ажлын хэсгийн 2 номер.

Б.Лхагвасүрэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Эхлээд тэр түлш шатахуунтай холбоотой. Тэнд нөгөө би түрүүн танилцуулгадаа хэлсэн. Энэ ингээд түлш шатахуунд тодорхой хэмжээний эх үүсвэр гаргахаар репо санхүүжилтээ хийгээд явж байгаа. Яах вэ, репо санхүүжилтийн ерөөсөө, ер нь манай журмын дагуу 24 сар олгодог. Тэгээд бодлогын хүүгээрээ олгоод, репо санхүүжилтийн хүүгээрээ олгоод ингээд явчхаад байгаа юм. Тэгэхээр нөгөө 21 онд

өгсөн зээл маань энэ 23 онд ингээд дуусаж байгаа учраас тэгэхдээ өнөөдрийн үүсэж байгаа нөхцөл байдалтай нь холбогдуулаад нэг жилээр сунгая гэдгээрээ л энэ асуудлыг ингээд хөндөөд явж байгаа юм.

Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг Улсын Их Хурал баталсан. Тэгээд Улсын Их Хурлаар баталж байгаа явцад яг таны саяын хөндөж байгаа ХХАА-н ялангуяа МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үүндээ холбоотой бас санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэхээр бас санхүүжүүлтийг шийдэхээр шийдэхээр яригдсан. Тэгээд ирэх оны төсөв дотор Хүнс, хөдөө аж ахуйн яамны багц дотор улсын төсөв дотор 125 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлтийн ийм дүн явж байгаа. Энэ нь өөрөө ирэх онд нэг одоо бол энэ дүнгээрээ нэг 6 зуугаад тэрбум төгрөг гарчихсан байгаа юм. Тэгэхээр 1 их наядын хэмжээний эх үүсвэрийг гаргах боломжтой учраас цаана нь үлдэж байгаа 300-400 тэрбум төгрөгийг ирэх жил олговол ялангуяа таны ярьж байгаа махан дээр тэгээд бас бусад юун дээр нь энэ ажиллах боломжтой байгаа юм, тийм.

Ц.Цэрэнпунцаг: Тэгэхээр Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө, сая Энхтүвшин гишүүний асуусан асуултад тодорхой бид нар нэг ойлголт авлаа шүү. Одоо энэ гарцаагүй малчдынхаа энэ мах их бэлтгэгдсэн учраас үүнийг нь үнийг нь унахгүй байхын тулд бид нар мах худалдаж авч нөөцөлдөг тийм үү. Цааш нь боловсруулалт хийж байгаа махны үйлдвэрүүдэд ямар ч байсан эргэлтийн хөрөнгийг нь гаргах ийм их үүсвэр 300-400 тэрбум төгрөгийн эх үүсвэр өнөөдрийн бид нарын төсвийн хүүгийн хөнгөлөлт дээр тавьсан 125 тэрбум төгрөг цаашаа зээл болж гарахаараа одоо 600 гарчихсан байгаа. 400-гийн нөөц байгаа юм байна гэж ойлголоо шүү. Тэгээд үүнийг бид нар цаашидаа энэ асуудлыг ярилцахаар зэрэг үүнийг

гүнзгийрүүлж энэ дээр тодорхой ярилцана.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд тийм, ер нь Лхагвасүрэн Ерөнхийлөгч өө, ингээд нэг өнөөдөр бид нар энэ инфляц ингээд буурч ирж байна. Дан оронтой тоондоо ороод ирсэн. Махны үнэ ингээд багассан. Хамгийн гол юм бол бид нар өнөөдөр 1, 2 өдрийн дараах, 1 сарын дараах биш. Энэ хавар гарч ирдэг асуудлуудаа олж харах хэрэгтэй. Тийм ээ. Тэгэхээр өнөөдрийн бид нарын энэ асуудал энэ мэдээлэл сонсож байхад гарцаа байхгүй нэг тулгамдаж гарч ирж байгаа асуудал бол 3 сар, 4 сар, хавар юу болдог билээ, тийм ээ. Хавар нөгөө газар тариалангийн ажил эхэлнэ. Нөгөө хүнснийхээ дотооддоо бид нар тарьдаг, ургуулдаг өнөө тариа будаагаа тарихад шаардлагатай бензин, тосны асуудлыг бид нар өнөөдрөөс хангаж, эргэлтийг нь хангалттай, хадгалалт хэмжээндээ авч хадгалж нөөцлөх ийм бололцоог нь хангаж, энэ импорт нефть, нефтийн бүтээгдэхүүн импортолдог энэ компаниуд маань хангалттай эдийн засгийн эх үүсвэр, санхүүгийн эх үүсвэр байх ёстой.

Тийм учраас Монголбанк энэ ковидын үед, хүндрэлтэй үед энэ дээр энэ арга хэмжээг авч явуулаад энэ нь их үр дүнтэй гарсан учраас бид нар үүнийг цааш нь бас тодорхой хэмжээнд энэ 24 онд үргэлжлүүлж явуулах нь шаардлагатай байна гэж ингэж харж байгаа. Гишүүд ч гэсэн тодорхой санал хэлж дэмжлэгээ хэлсэн. Тэгэхээр зэрэг энэ дээр холбоотой бид нар өнөөдөр Байнгын хорооноос ер нь тогтоол гаргаж энэ чиглэл өгөх ийм бодолтой байна. Тэгээд энэ та бүхэндээ энэ гишүүддээ энэ Байнгын хорооныхоо өнөөдрийн гаргах Байнгын хорооноос гаргах тогтоолын төслийг та бүхэндээ ингээд уншиж танилцуулъя.

Бүгд харчихсан байна уу? Тараагаад өгчихсөн байгаа биз дээ. Ингээд би тогтоолынхоо төслийг уншичихъя. Тэгэх үү? Тийм.

Банкны хувьцаа эзэмшигчдийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон инфляцын өсөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар банкны хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах, хууль тогтоомжийн хэрэгжилт болон инфляцын нөхцөл байдал, инфляцад нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр банкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Монголбанкны мэдээлэлтэй танилцалтай холбогдуулан дараах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг Монголбанк Б.Лхагвасүрэнд даалгасгай.

1. Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 4 дүгээр зүйлийн 4.2, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг болон Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу банкныг нээлттэй ХК болгон өөрчлөх, өөрчлөн байгуулах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх ажлын хэрэгжилтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах,

2. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01

дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийн хугацааг сунгах талаарх саналаа хууль санаачлах эрх бүхий этгээдэд нэн яаралтай уламжлах,

3. Эдийн засагт үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, инфляцыг тогтворжуулах хүрээнд Төв банк Монголбанкны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан арга хэрэгслийг ашиглан, газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжихэд шаардлагатай санхүүжилтийн хугацааг сунгах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах гэсэн ийм тогтоолын төсөл өнөөдөр бэлдсэн.

Ингээд энэ тогтоолын төсөл дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд санал хураалт явуулж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.3 дахь хэсгийг үндэслэн Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя Санал хураалт.

Гишүүдийн 54,5 хувь нь дэмжиж, тогтоолын төсөл батлагдлаа.

Санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Банкны хувьцаа эзэмшлийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт болон инфляцын өсөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Монголбанкны мэдээлэлтэй танилцаж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Мэдээлэл өгсөн Монголбанкны ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ